



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 79

Номгон

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын  
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашиныг  
акталж данснаас хасах тухай

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2006 онд ашиглалтад орсон 13146100 төгрөгийн үнэтэй элэгдлээ 100 хувь нөхсөн УАЗ-315122 маркийн 52-39 БНА улсын дугаартай автомашины худалдах доод үнийг 1,0 сая төгрөгөөр тогтоож нээлттэй дуудлагын худалдааг 3 удаа зохион байгуулсан боловч нэг ч оролцогч ирээгүй. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 27 дугаар тогтоолоор анхны худалдах доод үнэ 1,0 сая төгрөгийг 50 хувиар бууруулж 500,0 мянган төгрөгөөр худалдах шийдвэр гарсан. Нээлттэй дуудлагын худалдааг 2019 оны 04 дүгээр сарын 18, 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрүүдэд зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй. Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 2/74 дугаар бүхий албан бичигт уг автомашин нь 2013 онд мотор цохиод зогссон түүнээс хойш ашиглалтын шаардлага хангахгүй болсон шалтгааныг дурдаад актлах саналыг ирүүлснийг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам"-ын 1.3, 6.1, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам"-ын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:



1. Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2006 онд ашиглалтад орсон 13146100 төгрөгийн үнэтэй элэгдлээ 100 хувь нөхсөн УАЗ-315122 маркийн 52-39БНА улсын дугаартай автомашиныг акталж данснаас хассугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.

2.1. Актлагдсан тээврийн хэрэгслээс ашиглаж болох сэлбэгийг худалдан борлуулж орлогыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх;

2.2. Актлагдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Хөрөнгийг комисс томилон хүлээн авч устгал хийх зардлыг тухайн байгууллагаас гаргуулах;

2.4. Тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 07 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 10 дугаар тогтоолын хавсралтын 6 дугаар мөр, 2019 оны 27 дугаар тогтоолын хавсралтын тээврийн хэрэгсэл хүснэгтийн 2 дугаар мөрийг тус тус хүчингүй болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР